

УЛААНБААТАР ХОТЫН ЗАЛУУЧУУДЫН ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ

П.Цэрэнбазар докторант, Философи социологийн коллеж,
БНХАУ-ын Жилиний Их Сургууль

Хураангуй:

Энэхүү ажлын гол зорилго нь амьдралын хэв маягийн судалгааны хүрээнд 1980-1990 оны хооронд төрсөн, Улаанбаатар хотод амьдардаг, дээд боловсролтой залуучуудын гэр бүл төлөвлөлтийн асуудлыг авч үзэж судлахад оршино. Судалгааны хүрээнд залуучуудын гэрлэлт, гэрлэлтийн сэтгэл ханамж, гэр бүл төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн сэтгэл ханамжийн асуудлыг гэрлэлтийн байдалтай холбож авч үзсэн.

Судалгааны үр дүнгээс гэрлэсэн залуучуудын гэрлэлтийн сэтгэл ханамж өндөр түвшинд байгаа бөгөөд гэрлэлт нь тэдний хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинд эерэг нөлөө үзүүлж байгаа дүр зураг харагдлаа.

Түлхүүр үгс: Гэр бүл, дан гэр бүл, нийлмэл гэр бүл, ерөөсгөл гэр бүл, гэр бүл цуцлалт

1. Үндэслэл

Манай улсыг хүүхэд залуучуудын орон гэж одоогоос 30 орчим жилийн өмнө тодорхойлж байсан. Тухайн үеийн төрөлтийн их давалгаа, “baby boom” буюу төрөлтийн тэсрэлтийн үргэлжлэл энэ цаг үед идэр залуу үеийг бүрдүүлж байна. Энэ утгаараа монголын өсвөр үе, залуучуудын талаар, тэдний хэрэгцээ шаардлага, амьдралын зорилго, үнэт зүйлс, үнэлэмжийн талаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил олон бий. Миний судалгааны ажлын бусад судалгаа шинжилгээний бүтээлүүдээс ялгагдах гол онцлог шинж нь амьдралын хэв маягийн асуудлыг Улаанбаатар хотод амьдардаг дээд боловсролтой залуучуудын жишээн дээр судалж үзсэнд оршиж байгаа юм. Улаанбаатар хотод амьдардаг, дээд боловсролтой, 1980-1990 оны хооронд төрсөн залуучуудын амьдралын хэв маягийг дөрвөн үндсэн чиглэлээр судалсан бөгөөд энэ өгүүлэлд залуучуудын гэр бүл төлөвлөлтийн байдлыг тодруулж, өмнө хийгдсэн бусад судалгааны материалуудтай харьцуулж авч үзлээ.

Санал асуулгын судалгааны удирдамж, хэрэглэгдэхүүнийг сэдвийн зорилго зорилтын

хүрээнд боловсруулж, Улаанбаатар хотод нэг сарын хугацаанд түүврийн хэмжээний дагуу мэдээллийг цуглуулсан. Судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо Улаанбаатар хотод амьдарч байгаа 1980-1990 оны хооронд төрсөн дээд боловсролтой иргэдийн тоог эх сурвалж болгон ашиглаж, энгийн санамсаргүй түүврийн аргаар 400 хариулагч сонгосон.

Улаанбаатар хотод 2010 оны байдлаар 1980-1990 оны хооронд төрсөн 275965 иргэн байгаагийн 100678 буюу 36,4% нь дээд боловсрол эзэмшсэн байна. Судалгаанд оролцогчдын 40 хувь нь эрэгтэй, 60 хувь нь эмэгтэйчүүд байв.

Судалгаанд оролцогчийг сонгохдоо нийгмийн үйл ажиллагааны бүхий л салбарыг жигд хамруулахыг хичээсэн. Энэ үндсэн дээр Улаанбаатар хотын 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын материалаас хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлийг удирдлага болгож дээд боловсролтой, 1980-1990 оны хооронд төрсөн залуучуудыг ажилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ажилтай гэсэн байдлаар ангилсан.

2. Залуучуудын гэр бүл төлөвлөлтийн өнөөгийн нөхцөл байдал

Цусан төрөл, гэрлэлт эсвэл үрчлэлтийн харилцаагаар холбогдсон хувь хүмүүсийн бүлэг болох гэр бүл нь нийгмийн тогтвортой байдлыг хангагч үндсэн институцийн нэг, нийгмийн хамгийн жижиг үндсэн нэгжийн хувьд нийгмийн дасан зохицлын үйл явц болон хувь хүний ухамсар, үзэл хандлагын өөрчлөлт тод харагдах нийгмийн орчин юм. Гэрлэлт, гэр бүлийн харилцааны гол субъект, хүн амын нөхөн үйлдвэрлэлийн гол цөм болж байдаг залуучуудын бүлгийн гэр бүл, гэрлэлтийн институцид гарч байгаа үйл явдал, өөрчлөлтийн талаар энэ хэсэгт авч үзье. Дээд боловсролтой нийгмийн гишүүд бодит амьдрал дээр өөрсөдөө болон үр хүүхэддээ олон давуу талыг олгож байдаг. Францын социологич Пьер Бурдьегийн судалгааны ажилд дурьдсанаар эцэг, эхчүүдийн боловсролын түвшин, ажил мэргэжил нь хүүхдүүдийн амьдралд томоохон нөлөө үзүүлж, бусдаас илүү боломж олгодог гэжээ¹⁷.

Монгол Улсад нэг эхнэр, нэг нөхөртэй байх моногами гэр бүлийн хэв маяг зонхилж, хуулиар баталгаажуулсан байдаг. Сүүлийн 10 жилд монгол гэр бүлийн бүтэц, хэв маягт дан гэр бүл 2000 онд 62,9% байсан бол 2010 онд 62,4%, нийлмэл гэр бүл 27,8%-с 24,9%, холимог гэр бүл 2,7%-с 2,1% болж бага зэрэг өөрчлөлтүүд гарчээ. Харин ганц биеэр амьдрагчид 2000 онд 6,5% байсан бол 2010 онд 10,6% болж өссөн байна.¹⁸ 2010 онд явуулсан судалгаанд оролцогч 35 хүртэлх насны гэрлэсэн залуучуудын 66% нь өөрийн гэр бүлийг дан, 26,2% нь нийлмэл, 7,8% нь өрөөсгөл (салсан, бэлэвсэн) гэр бүл гэж тодорхойлжээ.¹⁹

Ганц биеэр амьдрагчид нэмэгдсээр байгаа нь залуучуудын гэр бүлийн бүтэц, хэлбэрийн бас нэгэн онцлог болж цаашдаа ч өсөх төлөвтэй байна.

Залуучуудын ганц биеэр амьдрах шалтгаануудыг дурьдвал *нэгдүгээрт*, гэрлэлтийн насны эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ цөөн, *хоёрдугаарт*, эрэгтэйчүүд боловсрол, мэдлэгийн түвшингээр эмэгтэйчүүдээс хоцрогдсон,²⁰ *гуравдугаарт*, залуу хүмүүс гэр бүлийн амьдралд хангалттай бэлтгэгдээгүйгээс гэрлэсний эхний жилүүдэд салах нь түгээмэл байгаа,²¹ эцэст нь *дөрөвдүгээрт*, ажил төвт бүсгүйчүүд²² нэмэгдэж байгаа зэрэг болно.

Залуучуудын дунд хамтран амьдрах, гэрээгээр амьдрах, улс дамнасан, олон соёл бүхий гэр бүл, ижил хүйстэн гэр бүл зэрэг гэр бүлийн харилцааны олон хэв маяг бий болжээ. Гэрлэх нас хожууссан, залуучуудын чөлөөт амьдрал, биеэ даах эрмэлзэл, санхүү мөнгөний чадавхгүй байдал, байр сууцны асуудалтай холбоотойгоор хамтран амьдрах, гэрээт гэр бүлийн хэлбэр улам бүр хүлээн зөвшөөрөгдөж дэлгэрэх боллоо. Гэрлээгүй байгаа залуучуудын 40% нь гэрлэлтийн өмнө хамтын амьдралыг чухалчлан үздэгийн дээр гэрлээгүй дөрвөн залуу тутмын нэг нь хамтран амьдарч байгаад гэрлэх, 10,6% нь гэрлэхгүйгээр хамтран амьдрах сонирхолтой, гэрлээгүй дөрвөн залуу тутмын нэг нь гэрлэлтээ батлуулаагүй хамтран амьдрагчид байна²³.

Гэрлэлтийн эндогами (нэг анги, ястан, шүтлэг зэрэг ойролцоо хүмүүсийн гэрлэлт) хэв маяг зонхилж байгаа хэдий ч, экзогами (цусан төрлийн холбоогүй өөр бүлгээс гэрлэх) ёс журам дэлгэрэх байдал ажиглагдаж тэр нь улам баяжин, охид, эмэгтэйчүүд гадаад орны эрчүүдтэй гэр бүл болох явдал сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, хүмүүсийн ухамсарт энэ нь ердийн үзэгдэл хэмээн үзэх хандлага тогтож байна.²⁴

17 Н.Энх, Үндэсний мэдээ сонин, 2012.2.17. "Уул уурхайн салбарт 8700 ажлын байр бий болжээ", дахин ашиглав.

18 The Sociology of Youth Subcultures, Peace Review, 16:4, December (2004), pp. 409-414

19 УСГ, (2003). Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд, х.14, Улаанбаатар

20 НХХЯ, НҮБХАС, ФСЭЗХ, (2010), Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, НХХЯ, НҮБХАС, ФСЭЗХ, Улаанбаатар


21 УСХ, (2011). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн. Улаанбаатар

22 НХХЯ, НҮБХАС, ФСЭЗХ, (2010). Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. х.57

23 Б.Даш-Ёндон, (2009). Монголын нийгмийн өөрчлөлт, Улаанбаатар

24 Гал голомт хөдөлгөөн, (2004). Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар

Зураг 1. Гэрлэлт, цуцлалт (1000 хүнд ногдох)



Эх үүсвэр: ҮСХ, 2011. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2010

1990 онд 15-аас дээш насны 1000 хүнд ногдох гэрлэлтийн тоо 16,5 байсан бөгөөд энэ үзүүлэлт тасралтгүй буурсаар 2004 онд хамгийн доод цэгтээ (7,2) хүрч, 1989-1990 оныхтой харьцуулахад бараг 2 дахин буурсан бол 2005 оноос хойш энэ үзүүлэлт өсч, 2006 онд өмнөх оныхоос 2 дахин нэмэгдсэн байна. Гэвч энэ нь түр зуурын өсөлт байсан ба 2007 оноос буурсаар 2010 онд бүр 3,4-д хүрчээ (Зураг 1).

Манай орны хувьд гэрлэлт өндөр, цуцлалт бага, эрт гэрлэлт, эрт төрөлттэй байдаг ч сүүлийн 20 жилийн гэрлэлт цуцлалтын статистик үзүүлэлтийн динамикаас харахад гэрлэлт буурч, цуцлалт өссөөр байгаа ерөнхий хандлага ажиглагдаж байна.²⁵

Гэрлэлтийн ерөнхий төлвийг илэрхийлэх анхны гэрлэлтийн дундаж насны талаар 2004 онд хийгдсэн судалгаанд эрчүүд 27, эмэгтэйчүүд 25 настай байхад тохиромжтой²⁶ гэж үзэж байсан бол 2010 оны судалгаагаар эрэгтэйчүүд 25, эмэгтэйчүүд 24 насанд гэрлэвэл зохимжтой²⁷ гэжээ. Гэвч бодит амьдрал дээр гэрлэлтийн нас хожуу байгаа нь нэг талаас залуучууд амьдралын зорилго,

хүслээ биелүүлээгүй байгаа буюу гэрлэхэд бэлтгэгдээгүй байгаа, нөгөө талаас таарч тохирох хүнээ олоогүй байгаа явдалтай холбон тайлбарлаж байна.

Өмнөх нийгмийн тогтолцооны үед статистик мэдээнд айл өрхийг бүтцийн хувьд сэхээтэн өрх, ажилчин өрх, хоршоолсон малчдын өрх гэж ангилдаг байсан. Энэ ангиллаар 1984 оны байдлаар манай улсын хэмжээнд 65 мянга орчим сэхээтэн өрх байсан ба тэд нийт өрхийн 20,7 хувийг эзэлж байжээ. Тодруулбал, хотын өрхийн 33,3%, хөдөөгийн өрхийн 10,2% дээд боловсролтой гэр бүл байсан байна²⁸.

Улаанбаатар хотод 2010 оны байдлаар 1980-1990 оны хооронд төрсөн 275965 иргэн байгаагийн 100678 буюу 36,4% нь дээд боловсрол эзэмшсэн байна. Хүйсийн хувьд тэдний 40 гаруй хувь нь эрэгтэйчүүд, үлдэх 60 орчим хувь нь эмэгтэйчүүд байлаа.²⁹

Манай судалгаанд оролцогч Улаанбаатар хотын 22-32 настай, дээд боловсролтой залуучуудын 49,1% нь гэрлэсэн, 6,1% нь хамтран амьдрагчтай гэж хариулжээ. Харин салсан оролцогч 3,8 хувийг эзэлж байна.

25 Ц.Пүрэв, Б.Даш-Ёндон, (2009). Шинэчлэлийн үеийн өрх гэрийн харилцаа, х.205, Улаанбаатар


26 ШУА, ФСЭЗХ, (2012). Монголын залуучуудын нийгмийн дүр төрх, 20-21-р зууны зааг үе. х. 93, Улаанбаатар

27 Гал голомт хөдөлгөөн, (2004). Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар


28 НХХЯ, НҮБХАС, ФСЭЗХ, (2010). Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал

29 ШУА, ФСЭЗХ, (1987). Өнөөгийн сэхээтний нийгмийн төрх, х. 80 Улаанбаатар.

Зураг 2. Гэрлэлтийн байдал (хувиар)




Зураг 3. Эхнэр, нөхөртөө сэтгэл хангалуун байдаг эсэх (хувиар)



Судалгаанд оролцогч залуучуудын нас дээшлэх тусам гэрлэлтийн хувь өгсөж байгаа бол насны хувьд залуу байх тусам хамтран амьдрах, гэрлээгүй байх тохиолдол өсч байна. Сайхан мэдээ нь гэрлэсэн залуучууд 100% эхнэр нөхөртөө сэтгэл хангалуун байгаа явдал юм. Азтай

гэрлэгчдийн 70% нь эхнэр нөхрөө яг миний хүсч байсан заяаны хань маань гэж үзсэн бол үлдсэн 30% нь зарим талаар дутагдалтай ч хамт амьдрахад болохгүй зүйлгүй, хийсэн сонголтондоо харамсдаггүй гэж хариулжээ.

Зураг 4. Одоо байгаа хүүхдийн тоо (хувиар)



Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын төлөвлөсөн хүүхдийн тоо (нас, хүйс, хувиар)

Төлөвлөсөн хүүхдийн тоо	Хариулагчдын төрсөн он		Хариулагчдын хүйс	
	1980-1985	1986-1990	Эрэгтэй	Эмэгтэй
1	3.8	4.8	3.8	4.4
2	20.8	19.0	19.5	21.4
3	40.8	49.4	41.4	48.4
4	27.7	20.8	29.3	19.8
5	4.6	4.2	3.8	4.4
6	1.5	1.2	1.5	1.1
8	0.8	0.6	0.8	0.5

Хүүхдийн хувьд 1980-1985 оны хооронд төрөгсдийн гуравны хоёр нь хүүхэдтэй байгаа бол 1986-1990 оны хооронд төрөгсдийн 2/3 хувь нь хараахан хүүхэдтэй болж амжаагүй байна. Судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь ирээдүйд 2-4 хүүхэдтэй болохыг хүсдэг бол нэг л хүүхэдтэй байхад болно гэж 5 хүрэхгүй хувь нь үзжээ. 5 хүүхэдтэй болохыг хүсэгчдийн хувь нэг хүүхэдтэй болохыг хүсэгчдээс өндөр байна. Хамгийн олон буюу 40-50 орчим хувь нь 3 хүүхэдтэй болохыг илүүд үзжээ. Гэвч бодит байдал дээр хүүхдийн тоо хоёроос хэтрэхгүй байна.³⁰

1986 онд Философи, социологийн эрх зүйн хүрээлэнгээс явуулсан социологийн судалгаагаар нэг айлд байх хүүхдийн зохимжтой тоог малчид дөрвөөс доошгүй, сэхээтнүүд дээд тал нь 3 хүүхэд гэж үзжээ. Статистик мэдээнээс үзэхэд улсын дунджаар нэг эмэгтэйд 3,79 хүүхэд ногдож байсан ба хотод 3,25, хөдөөд 4,36 байв. Тэр дундаас дээд боловсролтой, Улаанбаатарт амьдардаг эхэд 2,85 хүүхэд ногдож байжээ. Улсын хэмжээнд нийт өрхийн 20,7 хувийг сэхээтэн, 38,2 хувийг ажилчин, 40,8 хувийг хоршоолсон ардын өрх эзэлж байв. Үүнээс сэхээтэн өрхийн 73,7% нь хотод, 26,4% нь хөдөө орон нутагт амьдарч байжээ.


³⁰ УСХ, (2012). Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүн, Улаанбаатар

Сэхээтэн өрх хүүхдийн тоог ухамсартайгаар зохицуулах байдлаас шалтгаалан тэдний дунд цөөн хүүхэдтэй өрх олширч байсан байна.³¹

Цаг хугацаа, хөрөнгө мөнгөний шалтгаан нэрлээгүй зүгээр л ойрын үед гэрлэх бодолгүй байгаа залуучууд судалгаанд оролцсон гэрлээгүй залуучуудын 70 орчим хувийг эзэлж байна. Харин бусад шалтгаанууд дотроос хөрөнгө мөнгөний

боломж тааруугаас гэрлэхгүй байгаа гэсэн хариултын хувь хамгийн өндөр байна. Энэ нь залуучууд гэр бүлийн амьдралд яарахгүй, амьдралын өөр бусад асуудлыг чухалд тавьж байгаагийн илэрхийлэл болж байна. Гэрлээгүй залуучуудын хувьд гэрлэж, үр хүүхэдтэй болохоос илүү боловсролоо дээшлүүлэх, материаллаг хэрэгцээгээ бүрэн хангах, албан тушаал дэвших, хувийн бизнес эрхлэх зэрэг зорилгууд нэн тэргүүнд тавигдаж байна.

Зураг 5. Гэрлэхгүй байгаа шалтгаан (нас, хувиар)



Судалгаанд оролцогчдын гэрлэхгүй байгаа шалтгааныг насны байдалтай авч үзэхэд 22-26 настай залуучуудын бараг 80 шахам хувь нь гэрлэхэд төдийлөн яарахгүй байв. Харин 27-32 насныхны хувьд гэрлэхэд хөрөнгө мөнгөний ба цаг хугацааны саад бэрхшээлүүд илүү тохиолдож байна.


Цаашлаад гэрлэлтийн байдлыг амьжиргааны түвшин, орлогын хүрэлцээ, байр сууцны төрөл, хувийн эзэмшлийн машин зэрэг материаллаг зүйлсээс гадна хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн сэтгэл ханамжтай холбон авч үзье. Учир нь гэр бүлийн хамтын амьдралд эхнэр, нөхөр, хүүхэд болон тодорхой субъектууд, тэдгээрийн харилцаанаас гадна ахуй

амьжиргаа, түүнийг нөхцөлдүүлэгч, хөдөлмөр эрхлэлт, орлого зарлагын хүчин зүйлүүд томоохон нөлөө үзүүлдэг билээ.

Судалгаанд оролцогчдын 60 хүрэхгүй хувь нь хувийн сууц эсвэл орон сууцанд амьдардаг байна. Гэр ба хашаа байшинд амьдрагчид 28,1 хувийг эзэлж байна. Үлдэх 10 гаруй хувь нь түрээсийн байр, хажуу өрөө, нийтийн байранд амьдардаг буюу өөрсдийн гэсэн орон сууцгүй ажээ. Судалгаанд оролцогчдын хувьд орон байрны асуудал харьцангуй боломжийн түвшинд шийдэгджээ. Цаашлаад судалгаанд оролцогч гурван хүн тутмын нэг нь хувьдаа автомашинтай байна.

31 УСХ, (2012). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн. х. 98, Улаанбаатар

Зураг 6. Орлогын хүрэлцээ (гэрлэлтийн байдлаар, хувиар)



Судалгаанд оролцогч гэрлэсэн залуучуудын амьжиргааны түвшин тэдний тодорхойлсноор дундаж хэмжээнд байгаа бол гэрлээгүй залуучуудын амьжиргааны түвшин бусдаасаа харьцангуй өндөр байна. Мөн салалтын байдал амьжиргааны түвшинд муугаар нөлөөлж байна. Амьжиргааны доогуур түвшинд байгаа

залуучуудын дийлэнх хувийг салсан, эсвэл хамтран амьдрагч залуучууд эзэлж байна. Судалгаанд оролцогчдын 5% нь удирдах албан тушаалд ажиллаж байгаа бол 60 гаруй хувь нь дунд ба гүйцэтгэх албан тушаалд ажилладаг байна. 20,5% буюу судалаанд оролцогчдын 1/5 нь ажилгүй бол 9,1% нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байлаа.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын гэрлэлт, хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар)

Гэрлэлтийн байдал	Хөдөлмөр эрхлэлтийн байдал				
	Ажилгүй	Дунд тушаалын ажилтан	Гүйцэтгэх албан тушаалтан	Хувиараа бизнес эрхлэгч	Удирдах албан тушаалтан
Гэрлэсэн	38,6	52,3	52,6	41,9	76,5
Хамтран амьдрагчтай	8,6	5,3	7,0	3,2	5,9
Салсан	0,0	4,0	5,3	6,5	5,9
Гэрлээгүй	50,0	37,7	35,1	48,4	5,9
Бусад	2,9	0,7	0,0	0,0	5,9

Судалгаанд оролцогч залуучуудын албан тушаал дэвшихэд гэрлэлт сайнаар нөлөөлж байна. Удирдах албан тушаалд ажилладаг залуучуудын 76,5% нь гэрлэсэн залуучууд байна. Дунд болон гүйцэтгэх албан тушаалд ажилладаг залуучуудын гэр бүлийн байдал ойролцоо байв. Харин салсан хүмүүсийн хувьд огт ажилгүй хүн нэг ч байсангүй. Судалгаанд оролцогч залуучуудын 3,8% нь гэр бүлээсээ салсан нь гэрлэсэн, огт гэрлээгүй залуучуудаас хамгийн бага хувийг эзэлж байгаа ч 100% хөдөлмөр эрхэлж байна. Гэр бүлээ цуцлуулсан залуучууд хувийн бизнес

эрхлэх, удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажиллах нь их байна.

Ажилгүй залуучууд нийт судалгаанд оролцогчдын 20 гаруй хувийг эзэлж байгаа ба тэдний дийлэнх нь огт гэрлээгүй байна. Ажилгүй залуучуудын ажил хийдэггүй шалтгааныг тодруулахад талаас илүү хувь нь санаанд таарах ажил олдохгүй байна гэсэн хариултыг өгчээ. Үүний дараа ажлын байрны шалгуурт тэнцэхгүй, гэрийн ажилтай зэрэг шалтгаанууд орж байна.

Нийт судалгаанд оролцогчдын 10 хүрэхгүй хувь нь өрхийн орлого хүрэлцээгүй гэж хариулжээ. 40 гаруй хувь нь өдөр тутмын хэрэгцээнээсээ гадна шаардлагатай эд зүйлсээ авах хэмжээнд хүрсэн мөн тэр хэмжээний залуучууд өдөр тутмын ойр зуурын хэрэгцээгээ л болгож явдаг байна. Харин 6 хүрэхгүй хувь нь үнэ цэнэтэй эд зүйл худалдан авч чадна гэжээ. Амьжиргааны түвшин, орлогын хүрэлцээний

байдал нь нас, хүйс болоод төрсөн газар нутгийн хувьд жигд ойролцоо түвшинд байв.

Цаашлаад албан тушаалын зэрэг дэвч амьжиргааны түвшинд нөлөөлөхгүй байна. Удирдах албан тушаалд ажиллагсад үнэ цэнэтэй, эсвэл хүссэн зүйлсээ авч чадахгүй байхад дунд болон гүйцэтгэх албан тушаалтнууд, ажилгүйчүүд үнэ цэнэтэй зүйлүүд, бүр юу хүссэнээ авдаг гэсэн хариултыг өгчээ.

Хүснэгт 3. Өрхийн орлогын хүрэлцээ, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар (хувиар)

Хөдөлмөр эрхлэлтийн байдал	Ойр зуурын хэрэгцээгээ хангаж чаддаггүй	Ойр зуурын хэрэгцээгээ хангадаг	Ойр зуурын хэрэглээнээс гадна шаардлагатай зүйлсээ авдаг	Үнэ цэнэтэй зүйлсийг авдаг	Юу хүссэнээ авч чаддаг
Ажилгүй	12,9	45,7	34,3	5,7	1,4
Дунд тушаалын ажилтан	7,3	44,7	40,7	5,3	2,0
Гүйцэтгэх албан тушаалтан	12,3	47,4	35,1	3,5	1,8
Хувиараа бизнес эрхлэгч	6,5	29,0	61,3	0,0	3,2
Удирдах албан тушаалтан	0,0	25,0	75,0	0,0	0,0

Амьжиргааны түвшин эрхэлж байгаа ажилтай холбоогүй ч орлогын эх үүсвэрүүдтэй шууд хамааралтай байгааг Хүснэгт 7-с харж болохоор байна. Амьжиргааны түвшин ямар ч байсан эцэг эх, ах дүүгийн тусламж бүх оролцогчдод их бага ямар нэг хэмжээгээр байгаа нь монголчуудын уламжлалт

сэтгэлгээний онцлог бие биенээ халамжлан асрах байдлын илрэл болж байна.

Өрхийн амьжиргааны түвшин дээшлэх тусам бизнесийн орлогын хувь нэмэгдэж, цалин болон бусад эх үүсвэрүүдийн орлогын хувь буурч байна.

Хүснэгт 4. Өрхийн орлогын хүрэлцээ, орлогын эх үүсвэрээр (хувиар)

Орлогын эх үүсвэр	Ойр зуурын хэрэгцээгээ хангаж чаддаггүй	Ойр зуурын хэрэгцээгээ хангадаг	Ойр зуурын хэрэглээнээс гадна шаардлагатай зүйлсээ авдаг	Үнэ цэнэтэй зүйлсийг авдаг	Юу хүссэнээ авч чаддаг
Цалин	52,9	61,3	66,5	38,9	57,1
Бизнесийн орлого	2,9	6,9	15,5	22,2	28,6
Ажлаас гадуурх ажлын хөлс	2,9	6,4	5,6	11,1	0,0
Хааяа олддог ажлын хөлс	17,6	10,4	5,0	11,1	0,0
Эцэг эх, ах дүүгийн тусламж	17,6	11,6	6,8	16,7	14,3
Тэтгэмж, тэтгэлэг	5,9	2,9	0,6	0,0	0,0
Бусад	0,0	0,6	0,0	0,0	0,0

Өрхийн амьжиргааны түвшин доогуур залуучуудын орлогын ихэнх хэсэг нь цалин, үүний дараа эцэг эх, ах дүүгийн тусламж, хааяа олддог ажлын хөлс болж байна. Амьжиргааны түвшин доогуур байгаа залуучуудын тогтмол орлогын эх үүсвэр нь ихэвчлэн цалин байгаа бол амьжиргааны түвшин дээшлэх тусам бизнесээс олох орлогын хувь өгсөж байна. Өөрөөр хэлбэл цалин, бизнесийн орлого зэрэг тогтмол

орлогын хувь нэмэгдэх тусам залуучуудын амьжиргааны түвшин дээшилж байна.

Орлогын эх үүсвэр ба эрхэлж байгаа ажилдаа сэтгэл хангалуун байх явдал хоорондоо шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл орлогын ихэнх хэсгийг нь цалин бүрдүүлдэг судалгаанд оролцогчид ажилдаа илүү сэтгэл хангалуун байдаг байна.


Хүснэгт 5. Ажлын сэтгэл ханамж, орлогын эх үүсвэрээр (хувиар)

Орлогын эх үүсвэр	Сэтгэл хангалуун	Дунд зэрэг	Сэтгэл дундуур	Огт сэтгэл ханамжгүй
Цалин	81,1	69,8	62,5	20,0
Бизнесийн орлого	10,9	12,1	4,2	0,0
Ажлаас гадуурх ажлын хөлс	3,4	8,6	4,2	20,0
Хааяа олддог ажлын хөлс	1,1	5,2	12,5	20,0
Эцэг эх, ах дүүгийн тусламж	3,4	3,4	16,7	40,0

Цаашлаад судалгаанд оролцогчдын 3,3% нь боломж гарвал одоогийн ажлаа шууд солих бодолтой байгаа бол 16% нь одоогийн ажлаа ер нь солих бодолгүй байгаа гэжээ. Судалгаанд оролцогчдын

80,7% нь цалин хангамж нэмэгдэх, тушаал дэвших боломжтой болох зэрэг нөхцөлүүдийг харгалзан үзэж ажлаа солих бодолтой байгаа ажээ.

Зураг 7. Залуучуудын ажлын байран дахь сэтгэл ханамж (хувиар)



Ажлаа солих бодолгүй байгаа судалгаанд оролцогчид бүгд ажилдаа сэтгэл ханамжтай байдаг байна. Ажилдаа сэтгэл ханамжгүй байх гол шалтгаан нь цалин хөлсний хангамжгүй байдал, албан тушаал дэвших боломжгүй байдал байгаа нь судалгаанд оролцогчдын хариултаас харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд оролцсон гэрлэсэн залуучуудын гэрлэлтийн сэтгэл ханамж өндөр байна. Нийт судалгаанд оролцогчдын 49,1% нь гэрлэсэн, 6,1% нь хамтран амьдрагчтай байв. Гэрлэсэн судалгаанд оролцогчид бараг 100% эхнэр, нөхөртөө сэтгэл хангалуун явдаг ажээ.

Хэдийгээр судалгаанд оролцогч гэрлэсэн залуучуудын гэрлэлтийн сэтгэл ханамж өндөр байгаа ч гэрлээгүй үлдсэн хэсэг нь гэрлэхэд төдийлөн яарахгүй байдал ажиглагдлаа. Тэдний 70 гаруй хувь нь ямар нэгэн шалтгаангүйгээр ойрын хугацаанд гэрлэх бодолгүй байв. Ойрын хугацаанд гэрлэх бодолгүй гэсэн хандлага судалгаанд оролцогчдын нас залуужих тусам илүү хүчтэй ажиглагдаж байгаа бол эдийн засгийн боломж тааруу, цаг зав муутайгаас болоод гэрлэж чадахгүй байх тохиолдол 27-32 насныхны дунд илүү байлаа.

Судалгаанд оролцогчид нас харгалзахгүйгээр 40-50 орчим хувь нь 3 хүүхэдтэй болохыг хүсдэг боловч бодит байдал дээр хүүхдийн тоо хоёроос хэтрэхгүй байна. 27-32 настай гэрлэсэн, хүүхэдтэй судалгаанд оролцогчдын 65 орчим хувь нь 2 хүүхэдтэй байгаа бол 22-26 настай оролцогчдын 34 орчим хувь нь 2 хүүхэдтэй байв.

Гэрлэлт ажил албан тушаалд сайнаар нөлөөлж байгаа нь удирдах албан тушаалд ажиллаж байгаа залуучуудын 75% нь гэр бүлтэй байгаагаас харагдаж байна. Залуучуудын хувьд цалин орлогын гол эх үүсвэр байгаа ба цалингийн хэмжээ нэмэгдэх тусам тэдний ажилдаа сэтгэл хангалуун байх хувь нэмэгдэж байлаа.

Гэрлэлтээ цуцлуулсан залуучууд 100% хөдөлмөр эрхэлж байгаа бол огт гэрлэж байгаагүй залуучуудын ажилгүйдлийн түвшин өндөр байна.

Судалгаанд оролцсон хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудын 50% нь огт гэрлээгүй бол 40% хувь нь гэрлэсэн байв. Тэдний ажил хийхгүй байгаа гол шалтгаан нь санаанд таарах ажил олдохгүй явдал байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэл дээр

Б.Даш-Ёндон, 2009. Монголын нийгмийн өөрчлөлт, Улаанбаатар

Гал голомт хөдөлгөөн, 2004. Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар

НХХЯ, НҮБХАС, ФСЭЗХ, 2010. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар

Ц.Пүрэв, Б.Даш-Ёндон, 2009. Шинэчлэлийн үеийн өрх гэрийн харилцаа, Улаанбаатар

ҮСГ, 2003. Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд, Улаанбаатар

ҮСХ, 2011. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн, Улаанбаатар

ШУА, ФСЭЗХ, 2012. Монголын залуучуудын нийгмийн дүр төрх, 20-21-р зууны зааг үе, Улаанбаатар

ШУА. ФСЭЗХ, 1987. Өнөөгийн сэхээтний нийгмийн төрх, Улаанбаатар

Англи хэл дээр

The Sociology of Youth Subcultures, Peace Review 16:4, December 2004